**Улс, Нийслэлийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудын зураг төслийг хянаж, баримталж буй бодлого чиглэлтэй нь уялдуулан, Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хэвийн найдвартай байлгах, хэрэглэгчдийг цэвэр усаар тасралтгүй хангах, гарсан бохир усыг татан зайлуулж цэвэрлэх үүргээ биелүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, шугам сүлжээтэй холбоотой зураг зөвшилцөх, техникийн нөхцөл олгох зэрэг ажлуудыг шуурхай хийж гүйцэтгэн хэрэгжүүлж байна.**

**МУЗГ-ын бодлого, УАБ-ын чиг хандлагыг хэрэгжүүлэх зорилгоор шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх төслүүдийн судалгааг боловсруулахад хамтран ажиллаж, хөрөнгө оруулалтын зардлыг тодорхойлсон нь төслүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх үндэс болсон.**

**Байгууллагад хэрэгжиж буй төсөл, зохион байгуулж байгаа ажлуудын үр дүнд олон дэвшилтэт үзүүлэлт гарсан бөгөөд шуудуу ухалгүйгээр шугам доторлогоог хэрэгжүүлж байгаа нь Монгол улсад анх удаа нэвтрүүлж буй дэвшилтэт технологитой ажил байлаа.**

**Байгууллагын 2019 оны бизнес төлөвлөгөөг дүгнэж, 2020 оны бизнес төлөвлөгөө болон 2016-2020 оны стратеги төлөвлөгөөний үндсэн чиглэл, арга замыг удирдлага болгон 2020 онд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.**

## 2020 оны зорилт

1. ШИНЭ САНАА,БҮТЭЭЛЧ ХАНДЛАГАТАЙ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭРХЭМЛЭГЧ ХҮНИЙ НӨӨЦТЭЙ БАЙХ.
2. ХАБЭА-Н ISO 45001: 2018 СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭХ
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ, УСНЫ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТЭД ТУЛГУУРЛАСАН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХ
4. ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ҮЙЛДВЭРЛЭЛД НЭВТРҮҮЛЖ, НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САНГ ХӨГЖҮҮЛЭХ
5. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ, БИЗНЕСИЙН ДЭГ ЖАЯГИЙГ БАРИМТЛАН ХЭРЭГЛЭГЧЭЭ ДЭЭДЭЛСЭН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ
6. ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛАХ

www.usug.mn



Анхаарал хандуулсанд баярлалаа!



# 2020 年度



# БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

## БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**УСУГ ОНӨААТҮГ нь МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ ЗЭРЭГ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН “Улаанбаатар хотын хэрэглэгчдийг унд ахуйн стандартад тохирсон усаар тасралтгүй хангаж, экологийн тэнцвэрийг хадгалах шалгуурт тохирох усыг байгальд нийлүүлэх” эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.**

**Нийт ажилчид 1816**

| | |
|---|---|
| Зөвлөх инженер | 11 |
| Мэргэшсэн инженер | 45 |
| Инженер техникийн ажилтан | 355 |
| Мэргэшсэн нягтлан бодогч, аудитор | 10 |
| Бусад ажилчид | 1461 |

Нийт ажилчид




**Цэвэр усны томоохон 7, жижиг 3 эх үүсвэр**
**Цэвэрлэх байгууламж 1**
**Бага оврын цэвэрлэх байгууламж 6**

Улаанбаатар хотын цэвэр усны дамжуулах шугамын нийт урт: **586 км**

Улаанбаатар хотын бохир усны шугамын нийт урт: **299.5 км**

| Шугам хоолойн төрөл | Уртын хэмжээ |
|---|---|
| Ган шугам | 310,2 км |
| Ширмэн шугам | 40,1 км |
| Полиетилен | 217,7 км |
| GRP хүчитгэсэн полиетилен | 18 км |




www.usug.ub.gov.mn

## БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА




| Эх үүсвэрүүд | Тогтоосон нөөц м³/хоног | | Одоогийн хэрэглээ м³/хоног |
|---|---|---|---|
| | 1980 он | 2015 он | |
| Төв | 90700 | 93840 | 55000-65000 |
| Үйлдвэр | 30300 | 16027,2 | 18000-23000 |
| МАХ | 8800 | 8018,6 | 8000-12000 |
| Дээд эх үүсвэр | 89300 | 73353,6 | 48000-51000 |
| Яармаг | 20000 | 20000 | 1100-1500 |
| Гачуурт | 25200 | 25200 | 7000-11000 |
| Буянт-Ухаа | 22500 | 22500 | 3600-4000 |
| Нийт | 286800 | 258939,4 | 145000-170000 |

| Усан сан түүний хүчин чадал | Эх үүсвэрийн усан сан | 7 байрлалд 34100м³ |
|---|---|---|
| | Түгээх усан сан | 11 байрлалд 46500м³ нийт 80600м³ |
| 2-р өргөгчийн насос станц | | 6 |
| Дамжуулан шахах насос станц | | 9 |
| Гүний худаг | | 218 |

Ус хангамжийн 7 эх үүсвэрийн 218 гүний худгаас хоногт **145,000-155,000** м3 цэвэр ус олборлон түгээж байна.
Бохир ус цэвэрлэх 7 цэвэрлэх байгууламж, 8 насос станцаар дамжуулан хоногт **170,000-190,000** м3 бохир усыг татан зайлуулж цэвэрлэн байгальд нийлүүлж байна.



## I. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ ЗЭРЭГ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАЛАА.**

Нийслэлийн засаг даргын тамгын газраас дэвшүүлсэн “Нэг хот-нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд байгууллагаас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 5 ажил 100 хувийн хэрэгжилттэй байна.

НЭГ ХОТ СТАНДАРТ
НИЙСЛЭЛИЙН АНХДУГААР ЗӨВЛӨГӨӨН

# I. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР, МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ:**

1. "Нийслэлийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн манай байгууллагатай холбоотойгоор хэрэгжих 8 ажлын хэрэгжилт 95.7%-тай байна.

| Үнэлэх боломжгүй | 0% | 40% | 70% | 100% |
|---|---|---|---|---|
| 1 | - | - | 1 | 6 |

2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд манай байгууллагатай холбоотойгоор хэрэгжих 15 ажлын хэрэгжилт 97%-тай байна

| Үнэлэх боломжгүй | 0% | 40% | 70% | 100% |
|---|---|---|---|---|
| 2 | - | - | 1 | 9 |



# II. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ:**

Дээд газрын тогтоол шийдвэрт манай байгууллагад хамааралтай 17 тогтоол шийдвэрийн 25 заалтын биелэлтийг нэгтгэж гаргасан бөгөөд биелэлтийн тайланг цахим хяналтын системд оруулсан. Үүнд:

- ✓ ЗГ-ын тогтоол -1
- ✓ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж - 1
- ✓ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл - 1
- ✓ Нийслэлийн Засаг Даргын захирамж - 8
- ✓ Нийслэлийн онцгой комиссоос өгсөн үүрэг даалгавар - 5
- ✓ Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл - 1

Нийслэлийн удирдах ажилтнуудын 8 удаагийн шуурхай зөвлөгөөнөөр манай байгууллагад хамааралтай 46 үүрэг даалгавар өгөгдсөнийг тогтоосон маягтын дагуу http://ulaanbaatar.mn/ онлайнаар хүргүүлж ажилласан

## III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

### 1. НИЙСЛЭЛИЙН ХҮН АМ, БАЙГУУЛЛАГА АЖ АХУЙН НЭГЖИЙГ УНД, АХУЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЦЭВЭР УСААР ТАСРАЛТГҮЙ ХАНГАХ, БОХИР УСЫГ ТАТАН ЗАЙЛУУЛАХ ҮНДСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ:

**А. Ус хангамжийн үндсэн 7 эх үүсвэр, 3 жижиг эх үүсвэрээс 2020 оны жилийн эцсийн байдлаар 54.08 сая шоо метр ус олборлохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 52.8 сая шоо метр ус олборлож хотын хэрэглээнд нийлүүлсэн байна. Шахсан борлуулсан усны харьцааг 2020 онд 14.1%-хувиас хэтрүүлэхгүй байх зорилго тавьж ажилласнаас гүйцэтгэлээр 16.1%-тай гарсан.**

Олборлон шахсан цэвэр усны төлөвлөгөө, гүйцэтгэл, м3/сар






III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**Б. Төв цэвэрлэх байгууламж болон бага оврын 5 цэвэрлэх байгууламжид 2020 онд 61.6 сая шоо метр бохир ус татан зайлуулахаар төлөвлөж жилийн эцсийн гүйцэтгэлээр 62.8 сая шоо метр буюу төлөвлөгөөнөөс 1.2 сая шоо метр бохир ус илүү татан зайлуулсан байна. Орлого болоогүй бохир усны хувь хэмжээг 24% байхаар төлөвлөж ажиллан гүйцэтгэлээр 28.9%-тай гарсан байна.**

Татан зайлуулсан бохир усны төлөвлөгөө, гүйцэтгэл, мян.м3



# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**В. Усны чанар, аюулгүй байдалд тавих хяналт, ариун цэврийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах талаар:**

- ✓ Ус хангамжийн эх үүсвэрүүд, дамжуулан шахах станц, усан сангууд, хэрэглэгч, ус түгээх байруудаас 4706 сорьц, үүнээс:
  - ✓ Давтан 157
  - ✓ Шугамын алдагдал 130
- ✓ Төлөвлөгөөт бус 391 сорьц, үүнээс:
  - ✓ Хэрэглэгчийн хүсэлтээр 242
  - ✓ Дотоод хяналтын 125
  - ✓ Иргэн, ААН-ийн гомдлын дагуу 24
- ✓ Төв цэвэрлэх байгууламж, болон бага оврийн цэвэрлэх байгууламжуудын технологи дамжлагын цэг, цэвэрлэгдэн гарч байгаа уснаас 598 сорьц
- ✓ Үйлдвэр аж ахуйн газар 970 сорьц
- ✓ Төлөвлөгөөт бус 358 сорьц, үүнээс:
  - ✓ Туршилт, дотоод хяналт 323
  - ✓ Хэрэглэгчийн хүсэлтээр 35

Нийт цэвэр усны **5097** сорьц, бохир усны **1926** сорьц авч зохих үзүүлэлтүүдийн дагуу шинжлэн, дүнг тухай бүрд мэдээллэж ажиллалаа.

www.usug.mn

# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**Г. Цэвэрлэх байгууламжуудад татан зайлуулсан бохир усыг стандартын шаардлагад нийцүүлэн байгальд нийлүүлэх талаар:**

Төв цэвэрлэх байгууламжид хүлээн авч байгаа бохир усыг 80%, бага оврын цэвэрлэх байгууламжуудад хүлээн авч байгаа бохир усыг дунджаар 95%-тай тус тус цэвэрлэн байгальд нийлүүлэхээр төлөвлөснөөс Төв цэвэрлэх байгууламж дунджаар **80.4%**, БОЦБ **93.9%**-тай цэвэрлэн байгальд нийлүүлсэн.




www.usug.mn

## III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

### Төв цэвэрлэх байгууламжид хүлээн авсан бохир усны бохирдлын үзүүлэлт, мг/л

Төв цэвэрлэх байгууламжид хүлээн авч байгаа бохир усны бохирдлын хэмжээ нь стандартаас 2-3.5 дахин өндөр байгаа нь биологи цэвэрлэгээ хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлэхгүй байна. Үүнтэй холбоотойгоор механик, биологи цэвэрлэгээг сайжруулах үүднээс арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллааг 6-аас 9-р сар хүртэл түр зогсоож, энэ хугацаанд ирж байгаа бохир усны бохирдлын хэмжээ буурч стандартад дөхөж очсон бөгөөд цэвэрлэгээний түвшин 85% хүртэл дээшилсэн.




## III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Урьдчилан цэвэрлэх байгууламжид арьс шир, ноос боловсруулах үйлдвэрүүдээс 2020 онд 490.07 мян.м$^3$ бохир ус хүлээн авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр **324.5 мян.м$^3$** бохир ус хүлээн авч механик болон химийн цэвэрлэгээгээр дунджаар **69.6%**-тай цэвэрлэн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлсэн.




Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрээс урьдчилан цэвэрлэх байгууламжид нийлүүлэх технологийн хаягдал усны техникийн шаардлага MNS 5582:2006 стандартыг хүчингүй болгож өгөх хүсэлтийг болон шаардлага үндэслэлийн талаар танилцуулга бэлтгэн СХЗГ-т явуулсан бөгөөд Байгаль орчны болон усны техникийн хороодын хамтарсан хуралд танилцуулга хийж 2021 оны 1 дүгээр сараас тухайн стандартыг хүчингүй болгох шийдвэрийг гаргуулсан.

**Арьс, шир, үслэг боловсруулах үйлдвэрийн технологийн хаягдал усанд агуулагдах гоплох бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ**

2-р хүснэгт.

| № | Үзүүлэлт | Зөвшөөрөгдөх дээд хэмжээ | Хэмжих нэгж |
|---|---|---|---|
| 1 | Умбуур бодис | 5500 | мг/л |
| 2 | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч | 6200 | мг/л |
| 3 | Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч /БХХ$_5$/ | 6[illegible]00 | мг/л |
| 4 | Хром /3 цэнэгт/ | [illegible] | мг/л |
| 5 | Сульфат | 150 | мг/л |
| 6 | Хлорид | 5400 | мг/л |
| 7 | Усны орчин pH | 9,0 | - |

# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**Байгууллагын санхүү, эдийн засгийн зорилтын биелэлт:**

Байгууллага нь 2020 оны жилийн эцсийн байдлаар **65375.5** сая төгрөгийн орлого олохоос гүйцэтгэлээр **63223.1** сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, нэхсэн дүнгээрээ орлогын төлөвлөгөөний биелэлт **96.7** хувьтай байна.

| Д/Д | Үзүүлэлт | 2019 оны гүйцэтгэл | 2020 оны зорилт | 2020 оны гүйцэтгэл | Биелэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тоогоор | | Хувиар | |
| | | | | | 2019 оноос | 2020 оны зорилтоос | 2019 оноос | 2020 оны зорилтоос |
| 1 | Үйл ажиллагааны орлого, сая.төг | 62456.7 | 65375.5 | **63223.1** | 766.4 | -2152.3 | 101.2 | **96.7** |
| 2 | Үйл ажиллагааны зардал, сая.төг | 76501.4 | 95995.4 | **84183.3** | 7681.9 | -11812.1 | 110.0 | **87.7** |
| 3 | Үйл ажиллагааны алдагдал, сая.төг | -14044.7 | -30619.9 | **-20960.2** | -6915.5 | 9659.7 | 149.2 | **68.5** |
| | ОНТНЗ, төгрөг | 1.22 | 1.47 | **1.33** | 0.11 | -0.14 | 108.7 | **90.7** |

# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**Байгууллагын санхүү, эдийн засгийн зорилтын биелэлт:**






### 3. ХЭРЭГЛЭГЧИЙН ГЭРЭЭ, УСНЫ БОРЛУУЛАЛТ, АВЛАГА, ТООЛУУРЖУУЛАЛТ БОЛОН ТҮҮНИЙ АШИГЛАЛТ, НЭГ ХҮНИЙ ХОНОГЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААР:

2020 онд шинээр **490** хэрэглэгчтэй цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах аж ахуйн гэрээ байгуулж, орон сууцны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага руу гэрээ шилжсэн, үйл ажиллагаа зогссон шалтгаанаар **194** хэрэглэгчтэй гэрээ цуцлагдаж нийт хэрэглэгчийн тоо **6451** болсон. Нийт хэрэглэгчийг үйл ажиллагааных нь чиглэлээр ангилбал:

| Алба, товчоо | Аж ахуй | Төсөв | Үйлдвэр | | Орон сууцны тусгай зөвшөөрөл эзэмшигч, амины орон сууц | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Үйлдвэр | Бохирдуулагч | | |
| Хэрэглэгчдэд үйлчлэх алба | 2713 | 520 | 355 | 166 | 1987 | **5741** |
| Зөөврийн ус хангах алба | 27 | 34 | - | - | 20 | **81** |
| Шугамаар ус хангах алба | 53 | 3 | - | - | 141 | **197** |
| Багахангай УСАТ | 23 | 19 | - | - | 390 | **432** |
| Нийт | 2816 | 576 | 355 | 166 | 2538 | **6451** |

III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

### 4. ХЭРЭГЛЭГЧДЭЭС АВАХ УСНЫ ТӨЛБӨРИЙН АВЛАГА:

Хэрэглэгчдээс авах усны төлбөрийн **9467.9** сая төгрөгийн авлагын **2875.7** сая төгрөг буюу 30.4%-ийг “Чандмань Налайх” ОНӨААТҮГ, **3139.0** сая төгрөг буюу 33.2%-ийг ОСНААУГ-ийн авлага тус тус эзэлж байна.
Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аж ахуйн нэгж байгууллагуудын авлага **1260.4** сая төгрөгөөр нэмэгдсэн.

| **Ангилал** | | Авлага /дараа сард төлөгдөх дүнг хассанаар/ | | Өсөлт/+/ бууралт/-/ /сая.төг/ |
|---|---|---|---|---|
| | | 2020.01.01 үлдэгдэл /сая.төг/ | 2020.12.31 үлдэгдэл /сая.төг/ | |
| **Нийт авлага /сая.төг/** | | **6857.4** | **9467.9** | **+2610.5** |
| **Үүнээс:** | ХУА | 6846.8 | 9345 | +2498.2 |
| | ШУХА | - | 55.2 | +55.2 |
| | ЗУХА | 2.7 | 48.9 | +46.2 |
| | БХУСАТ | 2.6 | 4.6 | +2 |
| | Авто бааз | 5.3 | 14.2 | +8.9 |

# III. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

**Байгууллагын цахилгаан, эрчим хүчний хэрэглээний талаар:**

Байгууллагын хэмжээнд 2020 онд 70.7 сая кВт.ц цахилгаан эрчим хүч ашиглах төлөвлөгөөтэй ажилласнаас гүйцэтгэлээр 64.85 сая кВт.ц цахилгаан эрчим хүч хэрэглэж бодит дүнгээр 5.85 сая кВт.ц (8.3%) буюу 1.36 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажилласан.







www.usug.mn

# III. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

Айл өрхийн 1 хүний хоногийн усны хэрэглээ 2020 жилийн эцсийн байдлаар

**112 л/хон**



Төвлөрсөн системд холбогдсон тоолууртай орон сууцны нэг хүний хоногийн хэрэглээ

**8.6 л/хон** **10,7 л/хон**





Ус хангамжийн сүлжээнд холбогдсон 323 ус түгээх байр

ЭНГИЙН 179 ус түгээх байраар үйлчлүүлж байгаа нэг хүний хоногийн хэрэглээ.

УХААЛАГ 144 ус түгээх байраар үйлчлүүлж байгаа нэг хүний хоногийн хэрэглээ.

**7.8 л/хон**



Зөөврийн ус хангамжтай 350 ус түгээх байраар үйлчлүүлж байгаа нэг хүний хоногийн хэрэглээ.

www.usug.ub.gov.mn

# III. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

## Хөрөнгө оруулалт, их ба урсгал засварын ажлын хэрэгжилт:

Байгууллагын хэмжээнд шинэ тоног төхөөрөмж худалдан авах, техник технологийн шинэчлэл, барилга байгууламжийн их ба урсгал засварын төлөвлөгөөнд нийт 371 ажил төлөвлөснөөс 356 ажил хийгдэж **96.0%**-ийн биелэлттэй, **10131.20** сая төгрөг зарцуулаад байна.




# III. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

## Нийслэлийн хөрөнгө оруулалтаар болон төлөвлөгөөт бус шугам сүлжээний засварын ажил



Автобус 2-н салаа цэвэр усны ф200мм шугамыг 190м газарт шинэчлэн сольсон.





Нийслэлийн хөрөнгөөр Сүхбаатарын талбайн урд талын “Хонхтой цэцэрлэг, Сити Тойлет”-н цэвэр болон бохир усны шугамын угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Цэвэр усны Ф-50мм шугам 300м, Бохир усны ф-150мм шугам өөрийн урсгалтай 200м, даралттай 100м шугамыг тус тус угсарч байнгын ашиглалтан оруулсан.

## III. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

### Шугам сүлжээний гэмтэл саатлын талаар:

2020 оны жилийн эцсийн байдлаар цэвэр усны төв шугам дээр **33** удаагийн гэмтэл, салбар шугам дээр **55** удаагийн гэмтэл бохир усны шугам дээр **27** удаагийн бөглөө, **33** удаагийн тунаа, хэрэглэгчийн бохир усны шугам дээр **52** удаагийн бөглөө үүссэнийг тухай бүрт шуурхай засварлан хэвийн ажиллагаанд оруулсан.

Төлөвлөгөөт ажлын хүрээнд:

•Цэвэр усны шугам дээр 55 хаалт сольсон.

•Цэвэр усны 685 худаг цэвэрлэж, 94 худгийн таг шинэчилж, 62 худагт шинээр шат суурилуулсан.

•Хавар, намрын бохир усны шугам угаалгаар 920 худаг хооронд угаалга хийж, худгийн хогыг цэвэрлэсэн.






www.usug.mn

## III. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

### ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ:

Тайлангийн хугацаанд нийт 1001 өргөдөл, гомдол ирснийг шийдвэрлэсэн.

| Ангилал | Нийт | Шийдвэрлэсэн өргөдөл |
|---|---|---|
| **Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв** | 365 | 365 |
| **ННЗБ бүртгэсэн Байгууллагад** | 576 | 576 |
| **1800-1200 дугаарын оператор** | 30 | 30 |
| **11-11 төвөөс ирсэн** | 21 | 21 |
| **Гар утасны аппликейшнээр ирсэн** | 4 | 4 |
| **E-Service** | 4 | 4 |
| **фейсбүүк** | 1 | 1 |
| **Нийт** | **1001** | **1001** |

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг баримтлан ажиллалаа.

Өргөдөл гомдлыг шийдвэрлэх дундаж хугацаа 2 хоног 3 цаг 25 минут байна.

www.usug.mn

## III. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

**Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл:**

Тайлант хугацаанд газрын даргын А тушаал 242, Б тушаал 1005, нийт 1247 тушаалыг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу боловсруулан батлуулсан.

edoc.ub.gov.mn цахим программаар 3441 албан бичиг ирсэн, гадагш 2568 албан бичиг явуулсан.

| Шийдвэрлэлтийн төрлөөр | Нийт ирсэн албан бичиг: 3441 | |
|---|---|---|
| | Хариутай | хариугүй |
| хугацаандаа шийдвэрлэсэн | 1854 | 1587 |
| хугацаа хэтэрч шийдвэрлэсэн | 4 | 2 |
| судалж байгаа | - | - |
| Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% |

Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8.91 хоног байна. Албан бичгийн индекс 0.7955 буюу "B" үнэлгээтэй байна. Нийт 3396 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт хийж, хаалтыг баталгаажуулсан.

Өмнөх онтой харьцуулахад хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн, шилжүүлсэн зөрчил 28 албан бичгээр буюу **47.1%**-иар буурсан.

www.usug.mn

## III. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн

**ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТАЛААР:**

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа 2020 оны төслийг боловсруулан MMCG XXK-аар гүйцэтгүүлсэн.

- 2020 онд УСУГ-ийн хэрэглэгчийн ДУНДАЖ СЭТГЭЛ ХАНАМЖ 7.6 буюу 76 хувийн сэтгэл ханамжтай байна. ДУНДАЖ сэтгэл ханамж өнгөрсөн онтой харьцуулахад 0.4 нэгжээр өссөн байна.
- Гэр хорооллын хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг өнгөрсөн онтой харьцуулахад ДУНДАЖ сэтгэл ханамж 0.3 нэгжээр өссөн бөгөөд орон сууцны хэрэглэгчдийн сэтгэл ханамж өнгөрсөн оноос 0.3 нэгжээр өссөн байна.
- Харин аж ахуйн нэгж байгууллагуудын ДУНДАЖ сэтгэл ханамжийн түвшнийг өнгөрсөн онтой харьцуулахад 0.6 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.






# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

**БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БОДЛОГО ШИЙДВЭРИЙГ ЦАХИМ ХУУДСААР МЭДЭЭЛСЭН БАЙДАЛ:**

Байгууллагын www.usug.mn Вэб сайтад цаг үеийн болон үйл ажиллагааны мэдээллүүд, тендер худалдан авалтын мэдээлэл, зар, урилга, техникийн нөхцөлтэй холбоотой мэдээлэл, хүний нөөцийн мэдээлэл, ажлын байрны тодорхойлолтууд, хууль эрх зүйн мэдээллүүдийг цаг тухайд нь зураг, дүрс бичлэг, тушаал захирамжийн хуулбар хавсралт баримтын хамт байршуулан олон нийтэд хүргэж байна.

Сошиал медиагийн хандалтад өдөр бүр хяналт тавин ажиллаж байгууллагын цахим хуудсанд www.eus.mn сайтаар төлбөрөө төлж хэвшихийг уриалсан видео бичлэг, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжүүдийг байршуулж ажиллалаа.








# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

**БАЙГУУЛЛАГАД ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД, УНДНЫ УСНЫ ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙГДЭЖ БАЙГАА АЖЛУУДЫГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**

- Усны үнэ цэнийн тухай 10 минутын телевизийн нэвтрүүлэг бэлтгэн ОТВ-ээр нэвтрүүлсэн.
- 2020 оны 06 сарын 01-нээс эхлэн хэт богино долгионы MGLRADIO-88,3 FM радиогийн “Нэг дусал” нэвтрүүлгээр байгууллагын түүх болон үйл ажиллагааг нийслэлчүүдэд хүргэж байна.
- Дэлхийн усны өдөрт зориулсан “Ус ба уур амьсгал” сэдэвт 3 сарын аяны төлөвлөгөөнд 3 бүлгийн 56 төрлийн ажил хийхээр төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллалаа.
- Байгууллагын үйл ажиллагааны болон цаг үеийн мэдээлэл, сургалт сурталчилгааны 71 мэдээллийг байгууллагын вэб сайт, фэйсбүүк цахим хуудас, ажилтнуудын фэйсбүүк бүлгэмд байршуулсан.

www.usug.mn

## IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

**БАЙГУУЛЛАГАД ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД, УНДНЫ УСНЫ ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙГДЭЖ БАЙГАА АЖЛУУДЫГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ АЖЛН ХҮРЭЭНД:**

Энэ онд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирсэн нийт 1728 хүсэлтийг хүлээн авч техникийн нөхцөл олгох комиссын хурлыг 20 удаа хуралдуулж, 501 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад албан бичгээр хариу өгч, 863 иргэн, аж ахуйн нэгжид техникийн нөхцөл олгож, 12 хэрэглэгчид зөвлөгөө өгсөн.






## IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

**ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ;**

2020 онд ХБГ-ээр иргэд хэрэглэгчдээс нийт 21304 дуудлага хүлээн авч, ХХХМС-ийн программд ангилан бүртгэлжүүлж, 100% барагдуулан ажилласан. Нийт дуудлагын 99.8%-ийг 1-8 цагийн хугацаанд шуурхай барагдуулан ажилласан.



# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

**Хүний нөөцийн бүрдэлт, хөдөлгөөний талаар:**

Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлон тухайн жилд ажиллах орон тооны саналыг даргын зөвлөлийн болон удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн НЗД-ын захирамжаар баталгаажуулан мөрдөн ажиллалаа.
Нийслэлийн Засаг Даргын 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/312 дугаар захирамжийг үндэслэн Ус сувгийн удирдах газрын даргын 03 дугаар сарын 18-ны өдрийн А/94 дугээр тушаал, Б/246 дугаар тушаалаар тус байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог 1892 ажилтантайгаар шинэчлэн баталсан. Батлагдсан орон тооны дагуу хүний нөөцөөр ханган ажиллаж 2020 онд нийт **1804** ажилтан ажиллаж байгаагаас удирдах ажилтан 23, инженер техникийн ажилтан 245, албан хаагч 107, мэргэжлийн ажилтан 1429 байна.




# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

## Бүтээлч, чадварлаг хүний нөөцийг төлөвшүүлэх

Байгууллагын бодлогын зорилго зорилтын хүрээнд Газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/41 тушаалаар батлагдсан “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх 85 ажил төлөвлөгдсөнөөс 55 ажил зохион байгуулагдаж биелэлтийн хувь 64.7% байна. 30 ажил Covid-19-н халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд НЗДТГ-н А/108, А/168 тоот захирамжийн дагуу зохион байгуулах боломжгүй болсон.

| Төлөвлөгөөний төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|
| Хүний нөөцийн сургалт хөгжил, идэвхжүүлэлтийн талаар | 36 ажил | 23 | 63.9% |
| Хүний нөөцийн эрүүл мэндийн талаар | 16 ажил | 16 | 100% |
| Хүний нөөцийн бие бялдрын чийрэгжилт болон биеийн тамир, спортын талаар | 24 ажил | 8 | 33.3% |
| Хүний нөөцийн нийгмийн асуудлын талаар | 9 ажил | 8 | 88.9% |
| Нийт | 85 ажил | 55 | 64.7% |



# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

## Бүтээлч, чадварлаг хүний нөөцийг төлөвшүүлэх

Газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/99 тоот тушаалын дагуу байгууллагын “Мастер төлөвлөгөөний зураглал 2030”, “Тогтвортой хөгжлийн стратеги 2030” боловсруулах ажил хийгдэж дууссан. “Мастер зураглал 2030”-ыг 50 ширхэг, “Тогтвортой хөгжлийн стратеги 2030”-ыг 100 ширхэг, “Үйл ажиллагааны төлөвлөгөө 2030”-ыг 50 ширхэг тус тус хэвлүүлсэн.






# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

## Бүтээлч, чадварлаг хүний нөөцийг төлөвшүүлэх

- 2020 онд 49 сургалтанд давхардсан тоогоор 1306 ажилтан хамрагдлаа.
- ХУД-ийн ОБХэлтэстэй хамтарсан галын дадлага сургалтыг зохион байгуулсан.
- Усны музейгээр 144 иргэн, номын сангаар 213 уншигч үйлчлүүлсэн. Цар тахлын улмаас номын сангаар үйлчлүүлэх ажилтны тоо багассан учир зөөврийн номын санг Дамбадаржаагийн цэвэрлэх байгууламж, Сэлбийн насос станц, Баянголын ус суваг ашиглалтын товчоонд тус тус ажиллуулж байна.





# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

**Шагнал, урамшууллын талаар:**

Байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтнуудын хөдөлмөр бүтээлийг үнэлүүлэхээр шагналд тодорхойлж:

- Төрийн одон медалиар 5 ажилтан,
- Яамдын шагналаар 113
- Нийслэлийн шагналаар 43 ажилтан
- Байгууллагын шагналаар 45 ажилтан

Нийт 206 ажилтан шагнагдсан байна.






# V. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Байгууллагын ХАБЭА-н төлөвлөгөөнд нийт 45 ажил төлөвлөснөөс 40 ажлын биелэлт гарч төлөвлөгөөний биелэлт 88.8%-тай байна. Байгууллагын хэмжээнд танхимаар **775**, цахимаар **1176** ажилтанд ХАБЭА-н сургалт зохион байгуулсан.

Байгууллагын ХАБЭА-н үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 2020 оны төлөвлөгөөнд ХАБЭА-н 45001:2018 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд "Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны хэмжилт, үнэлгээ, сургалт, судалгаа мэдээллийн төв"-тэй хамтарсан төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хэсгийг А/206 тоот тушаалаар томилж, 5 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан.

# V. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Ундны ус болон цэвэрлэгдээд гарсан бохир усны халдваргүйжүүлэлтэнд 1976-1990 онуудад ашиглагдаж байсан шингэн хлорын 1 тн-ы 180 ширхэг контейнер, 50 кг-ийн 129 ширхэг баллоныг 4-н задгай вагон, 20 тн-ын 2 чингэлгээр тээвэрлэн ОХУ-ын Кемерово хотын “Химпром” химийн үйлдвэрт хүргүүлж устгуулсан. Тус үйлдвэрээс баллоныг устгасан тухай актыг манай байгууллагад ируулсэн.









# V. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу “Коронавируст (Ковид-19) цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтанд Нийслэлийн усаар хангах албаны холбогдох инженерууд оролцож, Усаар хангах албаны штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн бэлэн байдалд ажилласан.











## COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн ажлын талаар

Нийслэлийн усаар хангах албаны бэлэн байдлын мэдээ, мэдээлэл, хүн хүч, багаж тоног төхөөрөмж, хамгаалалтын хувцас, хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, машин механизмын тооцоо судалгааг шуурхай гаргах, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан авах арга хэмжээг яаралтай төлөвлөх зорилгоор 13 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг Ус сувгийн удирдах газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн **"Шуурхай ажлын хэсэг томилох, ажлыг эрчимжүүлэх тухай"** А/232 тоот тушаалаар байгуулсан.







## COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн ажлын талаар

ЭМЯ, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс иргүүлсэн зөвлөмжийн дагуу **"ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ЗААВАР"**-ыг боловсруулан, Байгууллагын хэмжээнд жавелион, хлорт халдваргүйжүүлэгч уусмалаар давхардсан тоогоор 1901 цэг салбарын 143615м2 талбайд 2198 удаа ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн.









## COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн ажлын талаар

Ундны усны чанар, аюулгүй байдалд хяналт тавих зорилгоор **226 сорьц**, цэвэрлэх байгууламжуудад орж буй болон цэвэрлэгдээд гарч буй усны чанар, аюулгүй байдалд хяналт тавих зорилгоор **32 сорьц** авч, хими, нян судлалын шинжилгээ хийсэн.

Ундны усны халдваргүйжүүлэлтийн байдалд хяналт тавих зорилгоор үлдэгдэл хлорыг **161 удаа** хянасан байна.



## COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн ажлын талаар

Ус түгээгч, усны машины жолооч, бохир устай харьцан ажилладаг ажилтнууд, ус түгээх байраар үйлчлүүлдэг иргэдэд зориулсан зөвлөмжийн загварыг зурагт хуудас хэлбэрээр бэлтгэн хэвлэж, холбогдох зохион байгуулалтын нэгжүүдэд тараасан (4 төрлийн 803 ширхэг).





# COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн ажлын талаар

Байгууллагын хэмжээнд **14** нэр төрлийн 85385 ширхэг барааг (нэг удаагийн амны хаалт 71780 ширхэг, 1 удаагийн малгай 1000 ширхэг, нүүрний хаалт 3383 ширхэг, 1 удаагийн хамгаалалтын хувцас 3383 ширхэг, гар ариутгагч /санитол/ 300 литр, хуурай хлор 5 тн, жавелион 1 кг-аар 200 хайрцаг, гарын шингэн саван 500 гр-аар 87 ширхэг,агшин зуурын халаагч, гар угаалтуур 5 ширхэг, ионы гэрэл 30 ширхэг, аксона актив 160 литр, зөөврийн ор 15 ширхэг, ариутгалын багаж 27 ширхэг, биеийн халуун хэмжигч багаж 15 ширхэг) **168 349 350** төгрөгөөр худалдан авч ажилтнуудад олгосон.







# COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн ажлын талаар

Эрүүл мэндийн яамны мэргэжилтэнтэй хамтран хүн нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн зөв өмсөх, тайлах, гар угааж халдваргүйжүүлэх сургалтыг халдвар, хамгааллын дэглэмийг мөрдөн танхимаар 360, цахимаар 1176, нийт 1536 ажилтанд явуулсан.

Ажилтнууд ажлын байрандаа хамгаалах хувцас хэрэгслийг өдөр тутам зааврын дагуу зөв хэрэглэж буйд хяналт тавин ажиллаж байна





## COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн ажлын талаар

Нийслэлээс зардлыг нь шийдсэн хүн нэг бүрийн хамгаалах хувцас (750 ширхэг)-ыг хүлээн авч, бохир устай харьцан ажилладаг 250 ажилтанд олгох жагсаалтыг алба, товчоо, нэгж бүрээр болон нэгтгэл байдлаар гаргаж, хариуцсан инженерүүдэд хүлээлгэн өгсөн.






Нийслэлээс зардлыг нь шийдсэн тул 1 ширхэг ариутгалын хаалга худалдан авч цэвэрлэх байгууламжийн орох хаалганы коридорт байршуулсан.




## V. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

“Ажлын байранд хийх дасгал” хөдөлгөөний бичлэгийг хийж байгууллагын дотоод сүлжээнд байршуулсан. Хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлж тогтмол цагт дасгал хөдөлгөөн хийх дадлыг ажлын байранд бий болгосон.






## МЯНГАНЫ СОРИЛТЫН II КОМПАКТ ГЭРЭЭ
### Баруун эх үүсвэр






**САНХҮҮЖИЛТ:** **350 САЯ АМ.ДОЛЛАР**

Ус цэвэршүүлэх байгууламж, ус хангамжийн дамжуулах, түгээх сүлжээний ажлын зураг төслийг Престиж инженеринг ХХК болон АНУ-ын AECOM компаниуд гүйцэтгэж байна.

**ҮР ДҮН:**
Газрын доорх усны баруун эх үүсвэр буюу Улаанбаатар хотын баруун доод хэсэг /Биокомбинат, Шувуун фабрик орчим/-т шинэ эх үүсвэр байгуулах, хаягдал усыг дахин боловсруулах, усны салбарын тогтвортой байдлыг хангах

## МЯНГАНЫ СОРИЛТЫН II КОМПАКТ ГЭРЭЭ
### AquaRating үнэлгээ

Мянганы сорилтын сангийн Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд Олон улсын усны байгууллага (IWA)-аас УСУГ-т хэрэгжүүлсэн AquaRating аудитын ажил хийгдэж эцсийн тайланг ирүүлсэн . 2021 оны 1-р сарын 25-ны өдөр Олон улсын усны байгууллагын сертификатыг УСУГ-т гардуулах үйл ажиллагаа зохион байгуулагдана.









# Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр

**ШУГАМ ДОТОРЛОГООНЫ ТӨСӨЛ**

Төслөөр 2020 онд 5 км цэвэр усны шугам хоолойг доторлохоор төлөвлөн ажиллаж цэвэр усны ф150-300мм голчтой ган, ширмэн материалтай 3.6 км хоолойг Close-Fit технологиор доторлож нийт доторлосон шугамын урт 7.9 км болсон.

Доторлож шинэчилсэн шугам хоолой:

1. БЗД-ийн 6-р хороо, Бөхийн өргөөний уулзварын зүүн талаас Манлай баатар Дамдинсүрэнгийн гудамж хүртлэх хөндлөвч ф300мм ган шугам 680 метр, 5, 22-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Кино үйлдвэрээс Офицеруудын ордны аюулгүйн тойрог хүртлэх төвийн ф150мм голчтой ширмэн шугам 936 метр, 7-р хороо, Их тойруу, Туул жин пангийн төвийн ф200мм ган шугам 215 метр, 5-р хороо, Монгол кино нэгтгэл ТӨҮК-ээс Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг хүртэлх ф250мм ган шугам 330 метр шугам доторлож
2. ЧД-ийн 5-р хороо, Самбуугийн гудамж, төвийн ф250мм голчтой ширмэн шугам 500 метр, 4-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, Зоос гоёлын уулзвараас Байгалын түүхийн музей хүртлэх төвийн ф250мм ширмэн шугам 90 метр
3. СБД-ийн 3-р хороо, 31-р сургуулийн хойноос Сөүлийн гудамж хүртлэх төвийн ф300мм ширмэн шугам 52 метр, 8-р хороо, Усан бассейн сургалтын төвөөс Бээжингийн гудамж хүртлэх ф300мм ган шугам 106 метр
4. ХУД-ийн 3-р хороо, Эрчим хүчний ямнаас Автобус-1 баазын баруун тал хүртэлх ф200мм-ийн ган шугам 734 метр шугам







# Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр




Шугам доторлогооны технологийн олон улсад хэрэглэгдэж байгаа ISO 11295:2017 стандартыг Монгол хэл рүү орчуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Стандарт хэмжил, зүйн газарт батлуулах хүсэлтийг хүргүүлсэн. /ТХН/

## Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн ажлын явц

2019 он



2020 он



- 2020 оны байдлаар байгууламжруу орж гарах авто зам, гаргалгааны шугам, цахилгааны 35 кВ-ын дэд станц, болон технологийн 7 байгууламж, захирганы барилгын ажлын зураг тус тус хийгдэж зөвшилцсөн.
- Ажилчид байрлах байр, лаборатори болон төслийн барилгажих талбайн хөрс хуулалт, газар шорооны ажил хийгдсэн.
- Биологи цэвэрлэгээний байгууламжийн 1-р блок байгууламжийн суурийн арматурчлал, ул хавтангийн бетон цутгалтын ажил хийгдсэн.





## Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр

- **Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэн сайжруулах, шинэ цэвэрлэх байгууламжийг барих төсөл:**



Монгол улсын сангийн сайд Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн үнэлгээ хийх тухай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан.



Гүйцэтгэгчээр шалгарсан БНХАУ-ын “Чайна Тисижу Сивил Инженеринг” группээс дэлхий нийтэд тархаад буй Ковид19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажилд 2000 ширхэг амны хаалт хандивласан.

# Дүгнэлт

Байгууллага нь Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын системийн үйл ажиллагааг хэвийн найдвартай байлгах, хэрэглэгчдийг унд, ахуйн усаар тасралтгүй хангах, гарсан бохир усыг татан зайлуулж цэвэрлэх үүргээ биелүүлж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн ажлаа амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

Байгууллагын 2011-2020 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрт үнэлэлт дүгнэлт өгч, 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн стратегийг боловсруулан, цаашидын хөгжил, үйл ажиллагааны төлөвлөлтийн баримт бичгүүд болох “Мастер зураглал 2030”, “Тогтвортой хөгжлийн стратеги 2030”, “Үйл ажиллагааны төлөвлөгөө 2030” зэргийг боловсруулан гаргасан.





**Анхаарал хандуулсанд баярлалаа!**

# 2021 年度



# БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

## I. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР, МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ:**

1. “Нийслэлийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн манай байгууллагатай холбоотойгоор хэрэгжих 12 ажлын хэрэгжилт 97.5%-тай байна.

| Үнэлэх боломжгүй | 0% | 70% | 90% | 100% |
|---|---|---|---|---|
| 4 | - | - | 2 | 6 |

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 56 ажил төлөвлөснөөс хэрэгжилт 97.5%-тай байна.

| Үнэлэх боломжгүй | 0% | 40% | 70% | 100% |
|---|---|---|---|---|
| 3 | - | 3 | 4 | 46 |

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

# II. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ:**

Дээд газрын тогтоол шийдвэрт манай байгууллагад хамааралтай 34 тогтоол шийдвэрийн 51 заалтын биелэлтийг нэгтгэж гаргасан бөгөөд биелэлтийн тайланг цахим хяналтын системд оруулсан. Үүнд:



- ✓ Засгийн газрын тогтоол -1
- ✓ Улсын их хурлын тогтоол -1
- ✓ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж -2
- ✓ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл-2
- ✓ Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-5
- ✓ Нийслэлийн Засаг Даргын захирамж -20
- ✓ Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл -10
- ✓ Албан даалгавар-1

Нийслэлийн удирдах ажилтнуудын 36 удаагийн шуурхай зөвлөгөөнөөр манай байгууллагад хамааралтай 339 үүрэг даалгавар өгөгдсөнийг тогтоосон маягтын дагуу http://ulaanbaatar.mn/ онлайнаар хүргүүлж ажилласан

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**НИЙСЛЭЛИЙН ХҮН АМ, БАЙГУУЛЛАГА АЖ АХУЙН НЭГЖИЙГ УНД, АХУЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЦЭВЭР УСААР ТАСРАЛТГҮЙ ХАНГАХ, БОХИР УСЫГ ТАТАН ЗАЙЛУУЛАХ ҮНДСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ:**

**А. Ус хангамжийн үндсэн 7 эх үүсвэр, 3 жижиг эх үүсвэрээс 2021 онд 52.5 сая шоо метр ус олборлохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 56.29 сая шоо метр ус олборлож хотын хэрэглээнд нийлүүлсэн байна. Шахсан борлуулсан усны харьцаа 2021 онд 14.2%-хувиас хэтрүүлэхгүй байх зорилго тавьж ажилласнаас гүйцэтгэлээр 16.0%-тай, усны бодит алдагдал 11.8%-тай байна.**

**Олборлон шахсан цэвэр усны төлөвлөгөө, гүйцэтгэл, мян.м3**




www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**Б. Төв цэвэрлэх байгууламж болон бага оврын 5 цэвэрлэх байгууламжид 2020 онд 62.5 сая шоо метр бохир ус татан зайлуулахаар төлөвлөж жилийн эцсийн гүйцэтгэлээр 66.0 сая шоо метр буюу төлөвлөгөөнөөс 3.5 сая шоо метр бохир ус илүү татан зайлуулсан байна. Орлого болоогүй бохир усны хувь хэмжээг 24% байхаар төлөвлөж ажиллан гүйцэтгэлээр 27.9%-тай гарсан байна.**

**Татан зайлуулсан бохир усны төлөвлөгөө, гүйцэтгэл, мян.м3**






# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**В. Усны чанар, аюулгүй байдалд тавих хяналт, ариун цэврийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах талаар:**

- ✓ Ус хангамжийн эх үүсвэрүүд, дамжуулан шахах станц, усан сангууд, хэрэглэгч, ус түгээх байруудаас 3442 сорьц, үүнээс:
  - ✓ Давтан 130
  - ✓ Шугамын алдагдал 95
- ✓ Төлөвлөгөөт бус 619 сорьц, үүнээс:
  - ✓ Хэрэглэгчийн хүсэлтээр 285
  - ✓ Дотоод хяналтын 25
- ✓ Төв цэвэрлэх байгууламж, болон бага оврийн цэвэрлэх байгууламжуудын технологи дамжлагын цэг, цэвэрлэгдэн гарч байгаа уснаас 447 сорьц
- ✓ Үйлдвэр аж ахуйн газар 685 сорьц
- ✓ Төлөвлөгөөт бус 132 сорьц, үүнээс:
  - ✓ Туршилт, дотоод хяналт 61
  - ✓ Хэрэглэгчийн хүсэлтээр 63

Нийт цэвэр усны **4061** сорьц, бохир усны **1264** сорьц авч зохих үзүүлэлтүүдийн дагуу шинжлэн, дүнг тухай бүрд мэдээллэж ажиллалаа.

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**Г. Цэвэрлэх байгууламжуудад татан зайлуулсан бохир усыг стандартын шаардлагад нийцүүлэн байгальд нийлүүлэх талаар:**

Төв цэвэрлэх байгууламжид хүлээн авч байгаа бохир усыг 80%, бага оврын цэвэрлэх байгууламжуудад хүлээн авч байгаа бохир усыг дунджаар 95%-тай тус тус цэвэрлэн байгальд нийлүүлэхээр төлөвлөснөөс Төв цэвэрлэх байгууламж дунджаар **79%**, БОЦБ **95.8%**-тай цэвэрлэн байгальд нийлүүлсэн.




www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Урьдчилан цэвэрлэх байгууламжид арьс шир, ноос боловсруулах үйлдвэрүүдээс ХБГ-ээр 524.8 мян.м3 бохир ус хүлээн авч, механик болон химийн цэвэрлэгээгээр дунджаар 68%-тай цэвэрлэн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлсэн.

Урьдчилан цэвэрлэх байгууламжид татан зайлуулсан усны хэмжээ, м$^3$




www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**Байгууллагын санхүү, эдийн засгийн зорилтын биелэлт:**

Байгууллага нь 2021 оны жилийн эцсийн байдлаар **65082.6** сая төгрөгийн орлого олохоос гүйцэтгэлээр **67804.5** сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, нэхсэн дүнгээрээ орлогын төлөвлөгөөний биелэлт **104.18** хувьтай байна.

| Д/Д | Үзүүлэлт | 2020 оны гүйцэтгэл | 2021 оны зорилт | 2021 оны гүйцэтгэл | Биелэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тоогоор | | Хувиар | |
| | | | | | 2020 оноос | 2021 оны зорилтоос | 2020 оноос | 2021 оны зорилтоос |
| 1 | Үйл ажиллагааны орлого, сая.төг | 63223.1 | 65082.6 | 67804.5 | 4581.4 | 2722.0 | 107.2 | 104.2 |
| 2 | Үйл ажиллагааны зардал, сая.төг | 84192.7 | 89136.0 | 85637.3 | 1444.6 | -3498.7 | 101.7 | 96.1 |
| 3 | Үйл ажиллагааны алдагдал, сая.төг | -20969.6 | -24053.5 | -17832.7 | 3136.8 | 6220.7 | 85.0 | 74.1 |
| | ОНТНЗ, төгрөг | 1.33 | 1.37 | 1.26 | -0.07 | -0.11 | 94.8 | 92.2 |



# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**Байгууллагын санхүү, эдийн засгийн зорилтын биелэлт:**




Үйл ажиллагааны зардлын эзлэх хувь



# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

**ХЭРЭГЛЭГЧИЙН ГЭРЭЭ, УСНЫ БОРЛУУЛАЛТ, АВЛАГА, ТООЛУУРЖУУЛАЛТ БОЛОН ТҮҮНИЙ АШИГЛАЛТ, НЭГ ХҮНИЙ ХОНОГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААР:**

2021 онд шинээр **573** хэрэглэгчтэй цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах аж ахуйн гэрээ байгуулж, орон сууцны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага руу гэрээ шилжсэн, үйл ажиллагаа зогссон шалтгаанаар **67** хэрэглэгчтэй гэрээ цуцлагдаж нийт хэрэглэгчийн тоо **6873** болсон. Нийт хэрэглэгчийг үйл ажиллагааных нь чиглэлээр ангилбал:

| Алба, товчоо | Аж ахуй | Төсөв | Үйлдвэр | | Орон сууцны тусгай зөвшөөрөл эзэмшигч, амины орон сууц | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Үйлдвэр | Бохирдуулагч | | |
| Хэрэглэгчдэд үйлчлэх алба | 2876 | 518 | 387 | 183 | 2128 | **6092** |
| Зөөврийн ус хангах алба | 36 | 47 | - | - | 44 | **127** |
| Шугамаар ус хангах алба | 54 | 3 | - | - | 97 | **154** |
| Багахангай УСАТ | 23 | 19 | - | - | 391 | **433** |
| Нийт | 2989 | 587 | 387 | 183 | 2660 | **6873** |

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

**ХЭРЭГЛЭГЧДЭЭС АВАХ УСНЫ ТӨЛБӨРИЙН АВЛАГА:**

Хэрэглэгчдээс авах авлага 21130.8 сая төгрөг болсон нь оны эхнээс 11662.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь Засгийн газрын 211 дүгээр тогтоолын дагуу төрөөс төлөх цэвэр, бохир усны үйлчилгээний 9, 10, 11 дүгээр сарын төлбөр орж ирээгүй байгаатай холбоотой.

Нийт авлагын:

29.8 % буюу 6289.9 сая төгрөгийг ОСНААУГ

13.9 % буюу 2940.5 сая төгрөгийг "Чандмань Налайх" ОНӨААТҮГ-ын өр эзэлж байна

| **Ангилал** | | Авлага /дараа сард төлөгдөх дүнг хассанаар/ | | Өсөлт/+/ бууралт/-/ /сая.төг/ |
|---|---|---|---|---|
| | | 2021.01.01 үлдэгдэл /сая.төг/ | 2021.11.30 үлдэгдэл /сая.төг/ | |
| **Нийт авлага /сая.төг/** | | **9467.9** | **21130.8** | **+11663.0** |
| **Үүнээс:** | ХҮА | 9345.1 | 20612.9 | +11267.8 |
| | ШУХА | 55.2 | 286.7 | +231.5 |
| | ЗУХА | 48.9 | 175.1 | +126.2 |
| | БХУСАТ | 4.5 | 15.8 | +11.4 |
| | Авто бааз | 14.2 | 40.3 | +26 |

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

## III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

### ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ:

Байгууллагын хэмжээнд 68.4 сая кВт.ц цахилгаан эрчим хүч ашиглах төлөвлөгөөтэй ажилласнаас 66.56 сая кВт.ц цахилгаан эрчим хүч хэрэглэж бодит дүнгээр 1.84 сая кВт.ц (2.8%) буюу 602.1 сая.төг-ийн хэмнэлттэй ажилласан.










www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

## III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

### *Орон сууц, айл өрхийн нэг хүний хоногийн хэрэглээ:*

**112 л/хон**



Төвлөрсөн системд холбогдсон тоолууртай орон сууцны нэг хүний хоногийн хэрэглээ

**9.1 л/хон**



**10.5 л/хон**



Ус хангамжийн сүлжээнд холбогдсон **323** ус түгээх байр

ЭНГИЙН **179** ус түгээх байраар үйлчлүүлж байгаа нэг хүний хоногийн хэрэглээ.

УХААЛАГ **144** ус түгээх байраар үйлчлүүлж байгаа нэг хүний хоногийн хэрэглээ.

**8.4 л/хон**



Зөөврийн ус хангамжтай **350** ус түгээх байраар үйлчлүүлж байгаа нэг хүний хоногийн хэрэглээ.

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

## Хөрөнгө оруулалт, их ба урсгал засварын ажлын хэрэгжилт:

Байгууллагын хэмжээнд шинэ тоног төхөөрөмж худалдан авах, техник технологийн шинэчлэл, барилга байгууламжийн их ба урсгал засварын төлөвлөгөөнд нийт 308 ажил төлөвлөснөөс 226 ажил хийгдэж **73.3%**-ийн биелэлттэй, **5026.64** сая төгрөг зарцуулаад байна.






УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

## Шугам сүлжээний гэмтэл саатлын талаар:

2021 оны жилийн эцсийн байдлаар цэвэр усны төв шугам дээр **38** удаагийн гэмтэл, салбар шугам дээр **32** удаагийн гэмтэл бохир усны шугам дээр **29** удаагийн бөглөө, **19** удаагийн тунаа, хэрэглэгчийн бохир усны шугам дээр **15** удаагийн бөглөө үүссэнийг тухай бүрт шуурхай засварлан хэвийн ажиллагаанд оруулсан.

Төлөвлөгөөт ажлын хүрээнд:

- Цэвэр усны шугам дээр 42 хаалт сольсон.
- Цэвэр усны 696 худаг цэвэрлэж, 83 худгийн таг шинэчилсэн.
- Хавар, намрын бохир усны шугам угаалгаар 1722 худаг хооронд угаалга хийж, худгийн хогыг цэвэрлэсэн.






www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ:**

Тайлангийн хугацаанд нийт 1004 өргөдөл, гомдол ирснийг шийдвэрлэсэн.

| Ангилал | Нийт | Шийдвэрлэсэн өргөдөл |
|---|---|---|
| Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв | 450 | 441 |
| ННЗБ бүртгэсэн Байгууллагад | 517 | 517 |
| 1800-1200 дугаарын оператор | 25 | 25 |
| 11-11 төвөөс ирсэн | 6 | 6 |
| Гар утасны аппликейшнээр ирсэн | 2 | 2 |
| E-Service | 4 | 4 |
| фейсбүүк | - | - |
| Нийт | 1004 | 1004 |

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг баримтлан ажиллалаа.

Өргөдөл гомдлыг шийдвэрлэх дундаж хугацаа 2 хоног 10 цаг 22 минут байна.

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл:**

Байгууллагын даргын А-тушаал 262, Б-тушаал 766, нийт 1028 тушаалын боловсруулалт, холбогдох хуулийн үндэслэл, тушаалын хувийн хэргийн бүрдэлт, тушаалын төслийн сонсох ажиллагаа болон мэдэгдэх хуудсуудыг хэрэгжүүлэн ажилласан. edoc.ub.gov.mn цахим программаар 3396 албан бичиг ирсэн, гадагш 2374 албан бичиг явуулсан.

Нийт ирсэн бичгийн болон хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь - 99.97%:
Шийдвэрлэлтийн дундаж хугацаа - 7,72 хоног
Гарсан зөрчил : Шийдвэрлэлтийн хяналтыг цуцалсан - 18 бичиг
Хугацаа хоцорч шилжүүлсэн - 6
Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн - 1 зөрчил байна.

| Ирсэн бичгийн тоо | Хариутай | Хугацаандаа шийдвэрлэсэн | Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн | Судалж байгаа |
|---|---|---|---|---|
| 3396 | 1764 | 1565 | 1 | 66 |

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/
www.usug.mn

## III. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТАЛААР:**

Сэтгэл ханамжийн түвшин 2020-2021 онуудад дунджаас дээгүүр байна.




Сэтгэл ханамжийн судалгааны тайлангийн зөвлөмжийн дагуу Газрын даргын 2021 оны 11 сарын 10-ны өдрийн А/251 дугаар тушаалаар Үйлчилгээ, маркетинг сайжруулах багийг байгуулсан.

- Ахлагч -1
- Нарийн бичиг -1
- Гишүүд -13

**1** Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

**2** Байгууллагын брэндинг бий болгох

2022 оны төлөвлөгөө | 2 зорилго | 10 зорилт | 52 ажил

**Зөвлөмж**

- *Маркетингийн хэлтэстэй болох*
- *Ажилтнуудын харилцааны соёлыг сайжруулах*
- *Санал хүсэлт хүлээж авч байгаа болон шийдвэрлэж байгаа ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулах*

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

## IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

**БАЙГУУЛЛАГАД ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД, УНДНЫ УСНЫ ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙГДЭЖ БАЙГАА АЖЛУУДЫГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**

Байгууллагын вэб сайт дээрх “Ил тод байдал” цэсэнд нээлттэй ажлын байрны зарыг тухай бүр байршуулж, ажилд орох хүсэлтэй иргэдийн анкетыг цахимаар хүлээн авч хяналт тавин ажиллаж байна. Хууль эрх зүйн мэдээллүүдийг цаг тухайд нь зураг, дүрс бичлэг, тушаал, захирамжийн хуулбар, хавсралтыг баримтын хамт байршуулж, иргэд, байгууллагын нийт ажиллагсадын фэйсбүүк бүлгэм, фэйсбүүк цахим хуудастай холбож, мэдээлэл хүргэж байна.

Байгууллагын фэйсбүүк пэйж хуудасны шууд цахим шуудангаар ирсэн 58 захидлын асуулт, гомдол, санал хүсэлтэнд холбогдох албаны хүмүүстэй хамтран хариулт өгч, хэрэглэгчдэд хурдан шуурхай хариулт өгөх автомат хариулагч “Чаат боот” программыг ажиллуулж аюулгүй байдал, хэвийн ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.




www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

**БАЙГУУЛЛАГАД ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД, УНДНЫ УСНЫ ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙГДЭЖ БАЙГАА АЖЛУУДЫГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**

- Ковид 19 вирусээс урьдчилан сэргийлэх, угаарын хийгээс сэргийлэх заавар зөвлөмж, цар тахалтай холбоотой цаг үеийн мэдээллийг баталгаатай эх үүсвэрээс авч байгууллагын вэб сайт, фэйсбүүк пэйж хуудас, фэйсбүүк бүлгэмээр дамжуулан байгууллагын ажиллагсад болон хэрэглэгч, хандагч нарт нийт 128 мэдээлэл хүргэсэн.



- Дэлхийн усны өдрийг тохиолдуулан сургалт, сурталчилгаа, үйл ажиллагааны мэдээллийг нэвтрүүлж фэйсбүүк цахим хуудсаар 41269 хүнд, байгууллагын вэб сайтаар 398733 хүнд хүргээд байна.

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

Энэ онд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирсэн нийт 1620 хүсэлтийг хүлээн авч техникийн нөхцөл олгох комиссын хурлыг 21 удаа хуралдуулж, 460 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад албан бичгээр хариу өгч, 822 иргэн, аж ахуйн нэгжид техникийн нөхцөл олгож, 25 хэрэглэгчид зөвлөгөө өгсөн.




www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

**ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ;**

2021 онд ХБГ-ээр иргэд хэрэглэгчдээс нийт 15305 дуудлага хүлээн авч, ХХХМС-ийн программд ангилан бүртгэлжүүлж, 100% барагдуулан ажилласан. Нийт дуудлагын 99.8%-ийг 1-8 цагийн хугацаанд шуурхай барагдуулан ажилласан. Үүнд: Цэвэр бохир усны шугамын дуудлага 192, Гомдол санал хүсэлт 31, УТУТ-н төхөөрөмжтэй холбоотой дуудлага 4276, Усны захиалга 2585, Мэдээлэл лавлагаа хүссэн дуудлага 6871 хүлээн авч барагдуулсан байна.




www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

**Хүний нөөцийн бүрдэлт, хөдөлгөөний талаар:**

Нийслэлийн Засаг Даргын 2021 оны А/137 дугаар захирамжийг үндэслэн Ус сувгийн удирдах газрын даргын 2021 оны А/200 дугаар тушаалаар тус байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог 1892 ажилтантайгаар шинэчлэн батлсан. Батлагдсан орон тооны дагуу хүний нөөцөөр ханган ажиллаж 2021 онд нийт **1815** ажилтан ажиллаж байгаагаас удирдах ажилтан 24, инженер техникийн ажилтан 252, албан хаагч 110, мэргэжлийн ажилтан 1429 байна.




www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

## Бүтээлч, чадварлаг хүний нөөцийг төлөвшүүлэх

Хүний нөөцийн сургалт хөгжил, идэвхжүүлэлтийн үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөнд 12 ажил ажил төлөвлөгдсөнөөс 5 ажил хэрэгжиж 41,6% байна. 7 ажил Засгийн газрын 43-р тогтоол, Нийслэлийн засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 15-ны "Тогтоолын хэрэгжилтыг хангаж ажиллах тухай" 01/1005 дугаар захирамж, Газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" А/91 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажил, Covid-19 цар тахлын тархалтын улмаас зохион байгуулагдах боломжгүй болсон.

| Төлөвлөгөөний төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|
| Байгууллагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөгжүүлэх сургалтыг зорилтот бүлгийн хүрээнд зохион байгуулах | 4 ажил | 4 | 100% |
| Ажилтнуудын боловсролын байдал болон мэргэжил дээшлүүлэх, эрдмийн зэрэг горилох асуудалд дэмжлэг үзүүлэх | 2 ажил | 1 | 50% |
| Байгууллагын ажилтнуудын өөрийгөө хөгжүүлэх, мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх идэвх санаачлагыг өрнүүлэх | 5 ажил | 0 | 0% |
| Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих, нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох | 1 ажил | 0 | 0% |
| Нийт | 12 ажил | 5 | 41.6% |

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

## Бүтээлч, чадварлаг хүний нөөцийг төлөвшүүлэх

Байгууллагын нийт ажилтнуудын 2020 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 2021 оны 1 дүгээр сард зохион байгуулалтын нэгж бүрээр хийх ажлыг зохион байгуулж, нийт 1803 ажилтнаас 1767 ажилтан буюу 98.1 хувь нь хамрагдаж, байгууллагын дундаж үнэлгээ 92 байна. Энэ нь өмнөх оны дунджаас 0,8 функтээр өссөн үзүүлэлттэй байна.




Байгууллагын хэмжээнд нийт ажилтнууд үйл ажиллагааны гүйцэтгэлээ сар бүр тайлагнаж хэвшсэн бөгөөд бүтэн жилийн KPI үнэлгээг дотоодын хүний нөөцийн бүртгэлийн программаар хийх ажлыг холбогдох журамд заасны дагуу 2022 оны 1 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөж байна.

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

## Бүтээлч, чадварлаг хүний нөөцийг төлөвшүүлэх

Байгууллагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөгжүүлэх сургалтыг зорилтот бүлгийн хүрээнд дараах сургалтууд зохион байгуулагдсан. Үүнд:

- Байгууллагын удирдлага, менежментийн багийн нийт гишүүдэд зориулан хүний нөөцийн менежментийн шинэ чиг хандлага, хүний нөөцийн үе хоорондын ялгаа ба түүнийг хэрхэн удирдах, ментор ба коучинг, бүтээмж инновацийн талаарх сургалтанд нийт 40 ажилтан хамрагдсан
- Эдийн засаг санхүү бүртгэлтйн хэлтэс, Сургалт судалгааны төв, Хууль эрх зүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын хэлтсийн зарим ажилтан, зохион байгуулалтын нэгжүүдийн бичиг хэрэг хариуцсан ажилнуудад, бүтээмж инновацийн талаарх сургалтыг 2 удаа зохион байгуулсан
- ҮЭНХороотой хамтран Хүний нөөцийн ажилтнуудын өдрийг тохиолдуулан зохион байгуулалтын нэгжүүдийн бичиг хэрэг хариуцсан 25 ажилтанд зориулсан Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулга, хувь хүний хөгжил, гадаадад суралцаж ирсэн байгууллагын ажилтны шилдэг туршлагын талаарх сургалт, үйл ажиллагаар зохион байгуулав





www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

## Бүтээлч, чадварлаг хүний нөөцийг төлөвшүүлэх

- 16 удаагийн давтан сургалтад ЗУХА ба ШУХА –ны 629 ус түгээгч нар хамрагдаж, хөдөлмөрийн аюулгүй байдлын болон мэргэжлийн чиглэлээр хичээл заалгасан.
- Машинчийн 6 удаагийн давтан сургалтад 225 машинч нар зайнаас хамрагдсан
- Тоног төхөөрөмжийн засварчдын сургалтад ЗУХА-ны засварчид болон усан сангийн ариутгагч нарын 15 ажилтан, ШУХА-ны 12 засварчид хамрагдсан.
- Ус сурталчилгааны танхимаар энэ онд 217 иргэд, номын сангаар 38 уншигч үйлчлүүлсэн байна.







www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

## Шагнал, урамшууллын талаар:

Байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтнуудын хөдөлмөр бүтээлийг үнэлүүлэхээр шагналд тодорхойлж:

- Нийтийн аж ахуйн үйлчилгээний гавьяат ажилтан 1
- Төрийн одон медалиар 21 ажилтан
- Яамдын шагналаар 63
- Нийслэлийн шагналаар 34 ажилтан
- Байгууллагын шагналаар 9 ажилтан

Нийт 127 ажилтан шагнагдсан байна.









www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# V. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

ХАБЭА-н үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр нийт 32 ажил төлөвлөн ажилласнаас жилийн эцсийн байдлаар биелэлт 100 хувьтай байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын ХАБЭА-н дотоод дүрэм, ХАБЭА-н дотоод хяналтын журам, Аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх журмыг батлуулж, мөн ХАБЭА-н MNS ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд 14 журмыг боловсруулж батлуулсан. ХАБЭА-н менежментийн тогтолцоо MNS ISO 450015:2018 стандартыг байнгын сайжруулалтад хяналт хийлгэх зорилгоор дотоод аудитор 7 хүнийг бэлтгэн гэрчилгээ олгосон.

Монсертф ХХК-аар анхдагч баталгаажуулалтын аудитыг 2021 оны 12-р сарын 09-өөс 2021 оны 12-р сарын 13-ний өдөр хүртэл Төв оффисс, Ус хангамжийн алба, Цэвэрлэх байгууламжийн алба, Усны төв лабораторид хийлгэж, 2021 оны 12-р сарын 24-ний өдрийн Монсертф ХХК-ний удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр 2021 оны 12-р сарын 28-ны өдөр тус стандартын гэрчилгээг гардаж авахаар болсон.










www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# V. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй






УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# V. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

"ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ" хуулийн шинэчилсэн найруулга, УСУГ-ын ХАБЭА-н дүрэм, мэргэжилтэй ажилтнуудын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтийг танилцуулах сургалтын хөтөлбөрийн сургалтыг 2021 оны 10-р сарын 25-ны өдрөөс 11-р сарын 08-ны хооронд танхим, цахимаар зэрэг зохион байгуулж нийт 285 ИТА хамрагдсан. Сургалтын зохион байгуулахад Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны мэргэжилтэн Ц.Батнасан, Ш.Маяа, УСУГ-ын ҮЭНХ, ССТ, МТАН хамтран ажилласан.

Давтагдсан тоогоор ХАБЭА-н талаар 691 ажилтанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс шинээр ажилд орсон 108, хяналт шалгалт хийх явцад 227, утсаар болон цахимаар, уулзалт, сургалтаар 356 ажилтанд тус тус зөвлөгөө, мэдээлэл, зөвлөмж, заавар өгсөн байна. "УСУГ-ын гурван 10-н дүрэм", "аюулыг мэдээлэх хуудас"-ыг ЗБН-үүдийн ажлын байруудад байршуулсан.

Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, баталгаажуулалт, ХАБЭА-н ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ, Газрын даргын тушаалаар батлагдсан ХАБЭА-н дүрэм журмын хэрэгжилтэд төлөвлөгөөт мониторингийн үзлэг шалгалтыг 5 удаа зохион байгуулсан бөгөөд үзлэг шалгалтын явцад илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж давтагдсан тоогоор 68 удаагийн зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.









www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# V. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Ажлын байрны аюулын эрсдэлийг үнэлэх ажлыг Газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/134 дугаартай тушаалын дагуу хийж гүйцэтгэсэн. Байгууллагын хэмжээнд 519 аюулыг тодорхойлж эрсдэлийн түвшингээр нь ангилахад өндөр-112, дунд-278, бага-129 байна.

Аюулыг арилгах, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахад өндөр-10, дунд-30, Бага-479 болгон бууруулж, хяналтандаа авахаар ажиллаж байна.









УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн ажлын талаар

Монгол улсад мөрдөгдөж байгаа холбогдох хууль дүрэм журам, COVID-19 цар тахлын үед хэрэгжүүлж ажиллах журам, заавар дүрмийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн.

ЭМЯ, ХӨСҮТ-өөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу “ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ЗААВАР”-ыг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Цэвэрлэх байгууламжийн цэг салбарууд, ус түгээх байруудад өдөрт 2 удаа, бусад ажлын байруудад 7 хоногт 2-3 удаа жавелион, хлорт халдваргүйжүүлэгч уусмалаар халдваргүйжүүлэлт хийж хэвшсэн бөгөөд давхардсан тоогоор 1901 цэг салбарын 143615 м2 талбайд дээрх давтамжийн дагуу тогтмол халдваргүйжүүлэлт хийж байна.










www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

## COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн ажлын талаар

Ажилтнуудад зориулсан зөвлөмж, халдвараас урьдчилан сэргийлэх загварыг зурагт хуудас хэлбэрээр бэлтгэн дотоод сүлжээгээр түгээсэн.

Тусгаарлах өрөөнд тавигдах шаардлагад нийцүүлэн нийт 25 ажлын байранд тусгаарлах өрөөг бэлтгэсэн.

Байгууллагын хэмжээнд 2021 оны 12-р сарын 28-ны байдлаар 3-р тунд хамрагдсан 1620 ажилтан буюу 88.9% хамрагдсан байна. Эрүүл мэндийн шалтгаанаар вакцинд хамрагдах боломжгүй 100 ажилтан байна. Ковид 19-ийн халдвар авсан ажилтан байхгүй байна.









www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

## Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааны хүрээнд

### "USAID"-н шугамаар хэрэгжих Engendering Industries Program

Тайлангийн хугацаанд Мянганы сорилтын сан, АНУ-ын ЭСЯ, Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнге оруулалтын дэмжих хөтөлбөр төслийн нэгж, USAID –н Нийтийн аж ахуйн салбарын жендерийн оролцоог хангах хөтөлбөрийн багийн гишүүд, Токиогийн бохир усны байгууллага, JICA, KOICA-н Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран ажиллалаа.



АНУ-ын Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг "USAID"-н шугамаар хэрэгжих Engendering Industries Program буюу Нийтийн аж ахуйн салбарын жендерийн оролцоог хангах 2 жилийн хөтөлбөр 4 сарын 13-ны өдрөөс албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. Байгууллагыг төлөөлөн оролцох 3 гишүүн 2016-2020 оны хүний нөөцийн судалгаа, байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлттэй холбоотой мэдээллийг хүргүүлсэн.

Хөтөлбөрт оролцогч ажилтнууд 2 жилийн дадлагажуулах хөтөлбөр, АНУ-ын Жоржтауны Их Сургуулийн МкДоноугийн Бизнесийн сургуулийн 1 жилийн "Жендерийн тэгш байдлыг хангах манлайллын хөтөлбөр"-т оролцож байна.

**Үр дүн:** Хөтөлбөрт оролцогч ажилтнууд 2021 онд 17 удаагийн дадлагажуулах хөтөлбөр, 13 удаагийн 34 цагийн онлайн сургалтад хамрагдаж, 3 удаагийн фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан.

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааны хүрээнд

## ЖАЙКА болон Токио хотын бохир усны байгууллагатай хамтран ажиллах

ЖАЙКА-аас ирүүлсэн бохир ус цэвэрлэх байгууламж, шугам сүлжээ, тэдгээрийн ашиглалтын талаарх сургалтын мэдээллийг байгууллагын ажилтнуудад хүргэн 3 ажилтны нэрийг дэвшүүлэн, 1 ажилтан сонгон шалгаруулалтад тэнцэж сургалтад оролцож төгссөн.

БХБЯ-наас хүсэлт гаргасны дагуу ЖАЙКА-ийн хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавх бэхжүүлэх" төслийн судалгаанд хамтран ажилласан.

**Үр дүн:** УТЛ-ийн химич Б.Цагаанцэцэг "Operation and maintenance of sewerage system" онлайн сургалтад амжилттай хамрагдаж сертификат авсан.



Токио хотын бохир усны байгууллагаас "Өвсний үндэс, техник хамтын ажиллагааны төсөл" хэрэгжүүлэх хүсэлт гаргасны дагуу хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлэн, холбогдох судалгаа материалыг бэлтгэн хүргүүлж, "УСУГ-ын ариутгах татуургын засвар шинэчлэлтийн ажил эрхэлж буй ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх" чиглэлээр хамтын ажиллагааны саналаа өгөөд байна.

**Үр дүн:** ЖАЙКА-аас 2022 оны 3-4 сард төслийн саналд хариу өгнө.

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр

## Баруун доод эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл:

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр байгуулах, SCADA систем суурилуулах ажлыг хийж гүйцэтгэх тендерт Бүгд Найрамдах Турк Улсын "MAPA INSAAT Ve TIGARET AS" (МАПА) компани шалгарч барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна.





**Үр дүн:** МАПА компани Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн үндсэн таван барилгын суурийн газар шорооны ажлыг хийж байгаа бөгөөд барилга угсралтын ажлыг 2024 онд дуусган, туршилт тохируулгыг хийж, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр

**Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл:**

Олон улсын усны ассоциациас 8 бүлэг 112 үзүүлэлтээр, “Aquarating” үнэлгээний аргачлалаар хөндлөнгийн аудитыг хийж, “Хангалттай” үнэлгээ авсныг илтгэсэн гэрчилгээг манай байгууллагад гардуулсан.






**Үр дүн:** “Aquarating” үнэлгээний батламжилсан үр дүнд тулгуурлан УСУГ болон хөгжингүй орны ус ашиглалтын байгууллагын хооронд “Twinning” түншлэлийн хөтөлбөр хэрэгжүүлэх бөгөөд МСС хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагын сонгон шалгаруулалтыг 2022 оны 1-р улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр

**Улаанбаатар хотын цэвэр усны хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох төсөл:**

Ф200-300мм диаметртэй 2.415 км шугамыг Close-Fit аргаар, ф250-400мм диаметртэй 1.099 км шугамыг CIPP технологиор, нийт **3.514** км цэвэр усны шугамыг доторлосон.







**Үр дүн**: 2018-2021 онд нийт **11,78** км шугамыг доторлоод байна.

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

# Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр

**Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэн сайжруулах, шинэ цэвэрлэх байгууламжийг барих төсөл:**

БНХАУ-аас зохион байгуулсан цэвэрлэх байгууламжийн цахим сургалтад 25 ИТА-ыг хамруулж, тус цэвэрлэх байгууламжийн орон тооны саналыг хүлээн авсан.

Шинэ цэвэрлэх байгууламжийн 3 багц, 45 ажлын зураг төсөл, гаргалгааны сувгийн трассын 1 зураг, дулааны шугамын трасс, УДДТ-ийн байршлыг зөвшилцсөн.





**Үр дүн:** Барилга угсралтын ажлын явц 40%-тай байна.



# Бүтээлч ажил

- Бохир устай харьцан ажилладаг ажилтнуудад зориулан 16 заавар бүхий **"Ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн гарын авлага"**-ыг ИБХ, ЦБА, УТЛ, ХЭЗХАБХ, АБ, УЦБА-ны ИТА нар УХАТ-ын зөвлөх инженерүүд, МХЕГ, НЭМҮТ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулан гаргасан.






| № | Сэдэв | Боловсруулсан мэргэжилтэн |
|---|---|---|
| 1 | [illegible] | С.Бумаа Ц.Болормаа Б.Урнаа |
| 2 | [illegible] | С.Цэгмид НЭМҮТ С.Бумаа |
| 3 | [illegible] | С.Бумаа Б.Урнаа Ц.Болормаа |
| 4 | 4а. [illegible] | Б.Бадамжав Ю.Эрдэнэжаргал |
| | 4б. [illegible] | Ц.Чимэдсоронзо Б.Баярбилэг |
| 5 | [illegible] | С.Бумаа Б.Урнаа |
| 6 | [illegible] | Ц.Болормаа Б.Урнаа |
| 7 | [illegible] | |
| 8 | [illegible] | Ц.Болормаа Ю.Эрдэнэжаргал |



| № | Сэдэв | Боловсруулсан мэргэжилтэн |
|---|---|---|
| 9 | [illegible] | Б.Урнаа Ц.Болормаа С.Загдбазар |
| 10 | [illegible] | Ц.Болормаа |
| 11 | Лабораторид ажиллах аюулгүй ажиллагааны заавар | Ц.Болормаа С.Бумаа |
| 12 | [illegible] | С.Загдбазар |
| 13 | [illegible] | С.Бумаа Б.Баянзаян Б.Урнаа |
| 14 | [illegible] | Х.Хүрэлбат С.Загдбазар Б.Урнаа С.Бумаа |
| 15 | [illegible] | Б.Урнаа Х.Хүрэлбат С.Загдбазар С.Бумаа |
| 16 | [illegible] | С.Бумаа Б.Урнаа |

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# Бүтээлч ажил

- Шугам доторлогооны хэсэгт өндөр даралтын шугам угаалгын машины хошуу эвдэрсэн тул цэвэрлэгээний механик багажуудыг шинээр хийж ашигласан.





- 608, 652, 616, 644, 660 УТБ-ыг өөрсдийн хүчээр цэвэр усны төвлөрсөн шугаманд холбосон.







УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# Бүтээлч ажил

- Хэрэглэгчдэд чиглэсэн 51 төрлийн постер хийсэн бөгөөд давхардсан тоогоор 371000 хэрэглэгч мэдээллийг уншиж танилцсан байна.
- ДУСАЛХҮҮ ПОДКАСТ-ыг санаачлан 14 дугаараар дамжуулан 14 төрлийн сэдвээр хэрэглэгчдээс байнга асууж, мэдэхийг хүсдэг 85 асуултад хариулт өгч, зөвлөгөө өгсөн.






- Ажилтнуудын кипа автоматикийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалтын стенд угсарч PLC программчлалын сургалт зохион байгуулсан.





УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# Дүгнэлт

Байгууллагын 2021-2030 оны стратеги төлөвлөгөө болон 2021 оны бизнес төлөвлөгөөний үндсэн чиглэлийг удирдлага болгон өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын системийн өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид сайжруулах чиглэлийг тодорхойлохын тулд бүх үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний нөөц, ундны усны аюулгүй байдалд олон улсын болон хөндлөнгийн аудитын байгууллагууд аудит хийсэн.

Цэвэр усны шугамыг шуудуу ухалгүйгээр доторлох, Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Баруун доод эх үүсвэрийг байгуулах, хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр барих, гэр хорооллын ус түгээх байруудыг автоматжуулах, гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих зэрэг томоохон төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Коронавирусын халдварын үед байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй удирдлагаар хангах, ажилтнуудыг халдварт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Шуурхай ажлын хэсгийг байгуулан ажилласны үр дүнд хатуу болон хэсэгчилсэн хөл хорионы үед Нийслэлийн хүн амыг стандартын шаардлага хангасан ундны усаар тасралтгүй хангаж, гарсан бохир усыг татан зайлуулж, ажилтнуудыг 1, 2-р тунгийн дархлаажуулалтад 98.7% хамруулж, өвчлөлөөс урьдчилан сэргийлж ажилласан.

Үндсэн үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнд олон дэвшилтэт ахиц гарч Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааг хэвийн найдвартай байлгах үүргээ биелүүлж, дэвшүүлсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа гэж дүгнэж байна.

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР

# 2022 оны зорилт

1. ИННОВАЦИ БҮХИЙ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЖ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ
2. ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАСАН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ, ЧАДВАРЛАГ ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ
3. УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ЭКОЛОГИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ ХАНГАЖ, УСНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ
4. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУДЫГ НЭВТРҮҮЛЭХ
5. ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛАХ.
6. ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ НЭВТРҮҮЛЭХ
7. БАЙГУУЛЛАГЫН ГАМШИГ, ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХ
8. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДИЖИТАЛ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ

www.usug.ub.gov.mn https://www.facebook.com/USUG.UB/


УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР
1959
ОНООС
УЛААНБААТАР ХОТ
Анхаарал хандуулсанд баярлалаа!

# 第 1 回渡航

## 3. UB 市組織図

# ウランバートル市

## City Council（市議会）

## Governor of the Capital City and Mayoj of Ulaanbaatar city（首都知事兼ウランバートル市長）

- Vice Mayor in charge of Development Policy（開発政策担当副市長）
- Vice Mayor in charge of Human development/Social Policy（人間開発・社会政策担当副市長）
- ~~Projects Leader（都市開発担当、イノベーション・技術担当、大気・環境汚染担当、道路運輸担当）~~
- General Architector / Director of Urban Development Agency（主幹建築家兼都市開発局局長）
- Head of Mayor's Office of UB city（市長事務所長）
- Head of Capital City Governor's Office（首都知事事務所長）

### Mayor's Office（市長事務所）

1. Administration Management and Finance Division（運営管理・財務課）
2. Internal Inspection Division（内部検査課）
3. Urban Engineering Facility Division（都市エンジニアリング施設課
4. City and Greening Facilities Division（都市・緑化整備課）
5. Waste Management and Coordination Division（廃棄物マネジメント・調整課）
6. Food Production, Trade and Service Division（食料生産・商業・サービス課）

### 知事事務所所属機関

1. Mongol Naadam Facility（モンゴルナーダム公社）
2. City Landscaping and Cleaning Service Department（都市整備局公社）
3. Ulaanbaatar Buyan Funeral Company（UBボヤン葬儀社）
4. USUG（UB上下水道公社）
5. Traffic Control Center（交通コントロールセンター）
6. OSNAAUG（住宅・公共サービス公社）
7. Ulaanbaatar Heating Network Company（UB暖房ネットワーク公社）
8. Ulaanbaatar Road Maintenance Company（UB道路維持管理公社）
9. Emergency Management and Coordination Center（緊急管理調整センター）
10. Ulaanbaatar Electricity Network Company（UB電力ネットワーク公社）
11. District Heating Company（地域暖房公社）
12. Geodesy and Water Facility Department（雨水施設管理局公社）

### Implementing Agencies（実施機関）

1. Road Development Department（道路開発局）
2. Air Pollution Reduction Department（大気汚染対策局）
3. Archive Department（公文書保管局）
4. Tourism Department（観光局）
5. Environment Department（環境局）
6. Sports Committee（スポーツ委員会）
7. Education Department（教育局）
8. Land Management Department（土地管理局）
9. Urban Development Department（都市開発局）
10. Housing Infrastructure Department（住宅インフラ局）
11. Internal Audit Department（内部監査局）
12. Family, Children and Youth Development Department（家族・子供・青年開発局）
13. Veterinary Department（獣医局）
14. Information Technology Department（情報技術局）
15. Professional Inspection Department（専門監査局）
16. Social Insurance Department（社会保険局）
17. Social Welfare Department（社会福祉局）
18. Public Service Department（公共サービス局）
19. Registration Department（登録局）
20. Emergency Department（非常事態局）
21. Property Management Department（管財経営局）
22. Statistical Department（統計局）
23. Culture and Art Department（文化芸術局）
24. Tax Department（税務局）
25. Public Transport Service Department（公共交通サービス局）
26. Labor Department（労働局）
27. Food and Agriculture Department（食料・農業局）
28. Procurement Department（調達局）
29. Police Department（警察局）
30. Science, Production and Innovation Department（科学・生産・イノベーション局）
31. Executive Judgement
32. Health Department（保健局）
33. Traffic Planning, Coordination and Engineering Department（交通計画、調整、エンジニアリング局）
34. Urban Standard, Environmental Safety Inspection and Coordination Department（都市基準・環境安全管理・調整局）

### Governor's Office（首都知事事務所）

1. Administraion Management Division（運営管理課）
2. Development Policy Division（開発政策課）
3. Project and Program Management Coordination Division（プロジェクト・プログラム管理調整課）
4. Finance and State Fund Division（財政・国家基金課）
5. Social Policy
6. Law Division（法務課）
7. External Relations and Cooperation Division（対外関係・協力課）
8. Monitoring and Evaluation Division（モニタリング・評価課）
9. Press Division（報道課）
10. Military Office（軍事所）

### 首都所属機関

1. Children's Palace（子供パラス）
2. Wedding Palace（結婚式場）
3. Children Food Company（保育園食品公社）
4. UB Bus Company（バス公社）
5. International Trade and Logistics Center（国際貿易ロジスティクスセンター）
6. Small and Medium-sized Business Support Center（中小企業支援センター）
7. Capital City Housing Corporation（首都住宅公社）
8. Children's Art Center（子供芸術学習センター）
9. Nalaikh Building Materials Industry/Technology Park（Nalaikh建材産業・技術パーク）
10. Investment Department（首都投資局）
11. Elderly Housing Company（高齢者住宅公社）
12. Urban Planning and Research Institute（都市計画調査研究所）
13. Ulaanbaatar ensemble（ウランバートル合唱団）
14. UB city Development Corporation（UB市開発コーポレーション）
15. Social Security Special Center（社会保障センター）
16. Cultural Center Palace（カルチャーセンターパレス）
17. Government Car Service Company（国営自動車公社）
18. Elevator Company（エレベーター公社）
19. Ulaanbaatar Fund（UB基金）
20. Children and youth education company（青少年教育センター）
21. National Central Park（国立公園）
22. Emeelt Light ITPark（Emeelt軽工業・技術パーク）
23. City Central Library（私立図書館）

# 第 1 回渡航

# 4. 上下水料金表

## 【モンゴル語】

**УЛААНБААТАР ХОТЫН**
**УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ**
**ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 01 өдөр Дугаар А/201 Улаанбаатар хот

Цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ,
тариф мөрдөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10 дахь заалт, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 79 дүгээр тогтоол, Ус сувгийн удирдах газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг тооцохдоо Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 79 дүгээр тогтоолыг даган мөрдсүгэй.

2.Монгол улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын хэрэгжүүлэх хугацааг сунгасантай холбогдуулан, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 24-ний 01/408 тоот албан бичгээр ирүүлсэн мэдэгдлийн дагуу төсөвт байгууллагын тарифыг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс, бусад хэрэглэгчийн тарифыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Хэрэглэгчдэд үйлчлэх албаны дарга (Ц.Баянзул), Багахангайн ус суваг ашиглалтын товчооны дарга (Ч.Батбаатар), Шугамаар ус хангах албаны дарга (Б.Баатархуяг), Зөөврийн ус хангах албаны дарга (С.Одгэрэл), Авто баазын дарга (Л.Энхтөгс)-д тус тус даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Эдийн засаг, санхүү бүртгэлийн хэлтэс(Ч.Ариунаа), Үйл ажиллагаа хяналтын хэлтэс (Д.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Ус сувгийн удирдах газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/251 дүгээр тушаалыг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс, 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/239 дүгээр тушаалыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ц.ТӨРХҮҮ

Tushaal-755.2021.USUG

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,**
**АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,**
**ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ**

14193 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Их тойруу 81/1, "Монгол Ньюс" тауэрын 6 давхар,
Утас: 7014 7445, Факс: (976) 7014 7444,
И-мэйл: info@wsrc.mn, Вэбсайт: www.wsrc.mn

2021.08.24 № 01/408
танай ______-ны №______-т

УЛААНБААТАР ХОТЫН "УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Ц.ТӨРХҮҮ ТАНАА

Тус Зохицуулах зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 79 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн тул тогтоолын эх хувийг хавсралтаар хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын хэрэгжүүлэх хугацааг сунгасантай холбогдуулан төсөвт байгууллагаас бусад хэрэглэгчийн тарифыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллана уу.

Хавсралт 4 хуудас.

ДАРГА Ж.БАТСҮХ-ҮРЬ

14?140294

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 08 сарын 12-ны өдрийн 5429 дугаарт бүртгэв.

# ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 21 өдөр Дугаар 79 Улаанбаатар хот

Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф батлах тухай

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний хүн амын тарифыг нэгдүгээр, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тарифыг хоёрдугаар, зөөврийн ус хангамж, бохир ус зөөврөөр татан зайлуулах үйлчилгээний тарифыг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн хугацааны дараа сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид "ТЗЭ" гэх/ аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тариф шинэчлэн батлагдсантай холбогдуулан борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ /цаашид "БОШ" гэх/-г хянуулж батлуулахыг ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2019 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар хавсралт, 2020 оны 108 дугаар тогтоолыг тус тус дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Ж.Гэрэлчулуун/-т даалгасугай.

ДАРГА Ж.БАТСУУРЬ

ГИШҮҮН Л.БОЛД

Ж.ДАВААЦЭРЭН

Г.ЦОГТСАЙХАН

Ч.ЭРДЭНЭЧИМЭГ

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 07 -р сарын 21-ны өдрийн 79 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт*

## Улаанбаатар хотын хүн амд мөрдөх цэвэр, бохир усны үйлчилгээний тариф

**(НӨАТ-гүй)**

| № | Үйлчилгээний төрөл | | Хэмжих нэгж | Тариф |
|---|---|---|---|---|
| 1. | Цэвэр ус | Тоолууртай | төг/л | 1.07 |
| | | Тоолуургүй | төг/л | 1.56 |
| 2. | Бохир ус | Тоолууртай | төг/л | 0.87 |
| | | Тоолуургүй | төг/л | 1.14 |

--- o O o ---

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 07 -р сарын 21-ны өдрийн 79 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт*

